МЭДЭЭ · 2020 оны 5-р сарын 1

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС АВСАН ЗЭЭЛЭЭ ТӨЛӨӨГҮЙ ИРГЭДИЙГ ОЛЖ ИЛРҮҮЛЭХЭД АНХААРЧ БАЙНА



Өвөрхангай аймгийн прокурорын газраас тус аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ажилтан, албан хаагчидтай уулзалт хийж, төрд учирсан хохирол, төлбөр барагдуулах ажлыг эрчимжүүлэх талаар санал солилцжээ.

Уг ажлын хүрээнд 2017 оноос 2020 оны 4 сар хүртлэх хугацаанд Өвөрхангай аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэгчийн хүсэлтээр эрэн сурвалжлагдсан сум хөгжүүлэх сангаас авсан зээлээ төлөөгүй иргэдийг шуурхай олж илрүүлэн, төрд учирсан хохирлыг барагдуулахад туслалцаа үзүүлэх зорилгоор тус аймгийн Цагдаагийн газартай хамтран ажиллахаар болсон байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3120